

ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
О.НАРАНДЭЛГЭР ТАНАА:

“ИЛТГЭХ ХУУДАС”

**”Клиринг,Төлбөр тооцооны журам”-ын хэрэгжилтэд  
хяналт, мониторинг хийсэн тухай**

2022.11.28

Дугаар.05

Улаанбаатар хот

**НЭГ. ХЯНАЛТ, МОНИТОРИНГИЙН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ**

**1.1. Хяналт, мониторингийн зорилго:**

Хяналт, мониторингийн зорилго нь “Клиринг,Төлбөр тооцооны журам”-ын хэрэгжилтэд хяналт, мониторинг хийх, “Төлбөр тооцоо, эрсдлийн удирдлагын хэлтэс”-т дотоод хяналт, шалгалт хийж, журмын хэрэгжилтэд хяналт тавих, хэрхэн үр ашигтайгаар хэрэгжүүлж, ямар үр нөлөөтэй ажилласанд дүгнэлт өгөх, илэрсэн алдаа дутагдлын шалтгаан нөхцлийг тогтоож, цаашид авах арга хэмжээний талаар дүгнэлт гаргаж, зөвлөмж өгч, холбогдох албан тушаалтнаар шийдвэрлүүлэхэд чиглэгдэнэ.

“Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хууль, Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны А/33 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Клиринг,Төлбөр тооцооны журам”, 2022 оны компанийн хяналт, шалгалтын ажлын төлөвлөгөө зэргийг тус тус үндэслэн төлөвлөгөөт дотоод хяналт, мониторингийн ажлыг хийж гүйцэтгэлээ.

**1.2. Хяналт, мониторингийн хамрах хүрээ**

1.2.1.“Төлбөр гүйцэтгэгч банкттай байгуулсан гэрээний хэрэгжилт;

1.2.2. Клиринг, төлбөр тооцооны дансны гүйлгээ, дэнчин барьцаа, төлбөр тооцоо;

1.2.3. Худалдах, худалдан авах гэрээ, хэлцэл;

1.2.5. Эрсдэлийн удирдлагын хэрэгжилт;

**1.3. Хяналт, мониторинг хийсэн бүрэлдэхүүн:**

Захиргаа, санхүүгийн хэлтсийн хяналт,мониторингын ахлах мэргэжилтэн  
О.Сайнжаргал

**1.4. Хяналт, мониторингод хамрагдсан хэлтэс:**

Төлбөр тооцоо, эрсдлийн удирдлагын хэлтэс

**1.5. Хяналт мониторингд хамрагдсан хугацаа:**

2022 оны 1 дүгээр сараас 2022 оны 11 дүгээр сар хүртэл

**1.6. Хяналт, мониторинг хийсэн хугацаа:**

2022 оны 11 дүгээр сарын 10-нээс 2022 оны 11 дүгээр сарын 25-н хүртэл

“Худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт, мониторинг хийх ажлын хүрээнд Төлбөр тооцоо,эрсдлийн удирдлагын хэлтэсээс гаргуулж авсан материалын жагсаалт:

1.	Төлбөр тооцоо гүйцэтгэгч банкны гүйлгээний журнал
2.	Клиринг,төлбөр тооцооны дансны гүйлгээний мэдээлэл ,дэнчин барьцаа,төлбөр тооцооны баримт / 9 хавтас/
3.	Хэлцлийн мэдээлэл, Худалдах, худалдан авах гэрээнүүд /16 хавтас/
4.	Эрсдлийн сангийн журам,хэрэгжилтийн талаарх мэдээлэл
5.	Клиринг,төлбөр тооцооны үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэх зөвлөх үйлчилгээний зөвлөмж,гэрээ дүгнэсэн акт

## **ХОЁР. ХЯНАЛТ, МОНИТОРИНГИЙН ҮР ДҮН**

Дотоод хяналт, шалгалтын ажлыг хийж гүйцэтгэхдээ 2021 оны 1 дүгээр сарын 01-ээс 2022 оны 11 дүгээр сарыг дуустал хугацааг хамааруулан хийж гүйцэтгэлээ.

### **2.1. Төлбөр гүйцэтгэгч банкттай байгуулсан гэрээний хэрэгжилт;**

Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын хэлтэс нь Монгол банкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн биелэлтийг хангасан,үйл ажиллагаа нь тогтвортой явагдаж буй манай улсын томоохон банкууд болох Хаан болон Голомт банкинд клиринг болон Төлбөр тооцооны дансыг нээж харилцагчдын гүйлгээг найдвартай түргэн шуурхай гүйцэтгэж ”Клиринг,Төлбөр тооцооны журам”-ын **2.5 дахь заалтыг** хэрэгжүүлж ажилласан байна.

Тус хэлтэс нь журмын **3.4 дахь заалтын** дагуу клиринг төлбөр тооцооны тайлан, банкаар хийгдсэн гүйлгээний журналыг 7 хоног бүр хөтөлж,сар,улирлаар нэгтгэн гаргасан байна.

### **2.2. Клиринг,төлбөр тооцооны дансны гүйлгээ, дэнчин барьцаа,төлбөр тооцоо;**

Төлбөр тооцоо, эрсдлийн удирдлагын хэлтэс нь журмын **3.3 дахь заалтын** дагуу биржийн гэрээний хэлцлийн бүртгэл,төлбөр тооцоо,дэнчин барьцаа,хөрөнгийн гүйлгээг, биржийн арилжаа,төлбөр тооцооны системд цахимаар, цагийн хуваарийн дагуу үнэн зөв гүйцэтгэсэн байна.

Тус хэлтэс нь журмын **4.10, 4.11-дахь заалтын** дагуу баталгаат болон анхдагч дэнчинг зуучлагч,арилжаанд оролцогчдоос урдчилж дансанд байршуулж, арилжаанд оролцогчдыг эрсдэлээс хамгаалж, журмын заалтыг хэрэгжүүлж ажилласан байна.

### **2.3. Худалдах,худалдан авах гэрээ,хэлцэл;**

Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын хэлтэс нь журмын **3.1 дахь заалтын** дагуу арилжааны дараахь төлбөр тооцоог харилцагчдын худалдах, худалдан авах гэрээний дагуу хийж, клирингийн үйл ажиллагааг үнэн зөв гүйцэтгэсэн байна.

Тус хэлтэс нь журмын **5.1 дахь заалтын дагуу** арилжаанд оролцогчдын хэлцэлийг худалдах, худалдан авах гэрээний дагуу баталгаажуулах ажлыг үнэн зөв гүйцэтгэсэн байна.

### **2.4. Эрсдэлийн удирдлагын хэрэгжилт;**

Төлбөр тооцоо, эрсдлийн удирдлагын хэлтэс нь журмын **4.1 дахь заалтын** дагуу арилжаанд оролцогчдын дэнчин болон барьцаа хөрөнгийг клирингийн дансанд төвлөрүүлж ажилласан байна.

Тус хэлтэс нь журмын **4.9 дахь** заалтын /Дэнчин нь дараахь төрөлтэй байна. **1. Баталгаат дэнчин 2. Анхдагч дэнчин 3.Тогтворт дэнчин 4.Төлбөр тооцооны дэнчин 5.Хүргэлтийн дэнчин/** дагуу баталгаат болон анхдагч дэнчинг клирингийн дансанд төвлөрүүлж, дэнчингийн хэмжээг журмын **4.8 дахь** заалтын /Дэнчингийн хэмжээг тогтоохдоо түүний төрөл болон биржийн гэрээний тодорхойлолтонд үндэслэн дараахь аргачлалын аль тохирохыг ашиглана. **1. Тогтмол 2. VAR 3. SPAN/** дагуу тогтмол аргачлалаар тодорхойлсон байна.

Журмын **4.16 дахь** заалтын дагуу биржийн клирингын эрхтэй гишүүд 150 сая төгрөгийн үнийн дүн бүхий барьцаа хөрөнгийг клирингийн дансанд байршуулж, худалдах, худалдан авах гэрээний төлбөр тооцоог журмын **3.2 дахь** заалтын дагуу клирингийн эрхтэй байнгын гишүүд гүйцэтгэж ирсэн байна.

Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг 2022-2026 оны төлөвлөгөөг батлуулж.Эрсдэлийн удирдлагын хороог байгуулж, биржийн Дотоод, Гадаад, Үйл ажиллагааны, Бизнесийн гэсэн ангилалтай 63 эрсдэлийг бүртгэлжүүлсэн байна.

### **Хяналт мониторингийн зөвлөмж:**

Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын хэлтсийн үндсэн үүргийн нэг болох биржийн эрсдлийн удирдагыг үр дүнтэй зохион байгуулах, мөн арилжаанд оролцогчдийн эрсдлийг хамгаалах зорилгоор дараахь ажлуудыг хийж гүйцэтгэх шаардлагатай байна.

1. Биржийн дотоод, гадаад, үйл ажиллагааны бизнесийн 63 эрсдэлийг шийдвэрлэх хугацааг нь зөв тодорхойлсон, аль хэлтсийн хэн гэдэг мэргэжилтэн хариуцах нь тодорхой, үр дүн нь тодорхой төлөвлөгөөг Эрсдэлийн удирдлагын хороогоор батлуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллах;
2. Журмын **4.9 дахь** заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дэнчингийн бусад төрлүүд болох тогтворт дэнчин, төлбөр тооцооны дэнчинг эрсдэлийн удирдлагад ашиглах, **4.8 дахь** заалтын дагуу дэнчингийн хэмжээг бодитойгоор тогтоохын тулд VAR болон SPAN аргачлалыг ашиглаж эхлэх;
3. Клиринг, төлбөр тооцооны үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэх зөвлөх үйлчилгээний зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах, Эрсдэлийн сан байгуулах журмыг боловсруулж, батлуулах;

Хяналт, мониторингийн зөвлөмжийн хүрээнд хийсэн ажил, үр дүнгийн тайланг 2022 оны 12 дугаар сарын 30-нээс өмнө Захиргаа, санхүүгийн хэлтсийн хяналт, мониторингийн ахлах мэргэжилтэн О.Сайнжаргал-д илгээнэ үү.

Хяналт мониторинг хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулсан:

Захиргаа, санхүүгийн хэлтсийн

Хяналт, мониторингын ахлах мэргэжилтэн

О.Сайнжаргал

Танилцсан:

Гүйцэтгэх захирал

О.Нарандэлгэр

Төлбөр тооцоо, эрсдлийн удирдлагын  
хэлтсийн менежер

Х.Оргил

